



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/222

Улаанбаатар хот

**Техникийн комиссын бүрэлдэхүүн,
журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.3.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” 282 дүгээр тушаалын 11.4, Эрүүл мэндийн сайдын А/602 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Эрүүл мэндийн салбарт нийлүүлэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийг эцсийн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллага хүлээн авахаас өмнө гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд туршилтаар ажиллуулах техникийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Техникийн комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга, техникийн комиссын дарга (П.Буяндэлгэр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд даргад даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭЦЭГСАЙХАН

142021 01222

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 15 өдрийн
4/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
222

ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн газрын дарга

Гишүүд

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн газрын Нийслэлийн эрүүл
мэндийн байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн шалгалт тохируулгын асуудал
хариуцсан мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн газрын Эрүүл мэндийн
байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн засвар тохируулга хариуцсан
мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн газрын Эрүүл мэндийн
байгууллагын дэд бүтэц, эмнэлгийн тоног
төхөөрөмжийн судалгааны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Төсөл хөтөлбөрийн тоног төхөөрөмж,
худалдан авалт хариуцсан мэргэжилтэн
(шаардлагатай тохиолдолд)

Эрүүл мэндийн яамны Лабораторийн
мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл
(шаардлагатай тохиолдолд)

Эрүүл мэндийн яамны Дүрс оношилгоо
судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн
төлөөлөл (шаардлагатай тохиолдолд)

Эрүүл мэндийн яамны Ерөнхий мэс засал
судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн
төлөөлөл (шаардлагатай тохиолдолд)

Эрүүл мэндийн яамны Нүүр ам судлалын
мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл
(шаардлагатай тохиолдолд)

Нарийн бичгийн дарга

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн газрын Орон нутгийн эрүүл
мэндийн байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн шалгалт тохируулгын асуудал
хариуцсан мэргэжилтэн